

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/70/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Алтай хот

2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413

Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055

Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах Аудитор

Д.Цэрэнханд

Утас: 99147999

Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.2 Төлбөрийн акт	15
4.3 Албан шаардлага	15
4.4 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022, 02.25 № 74

танай _____ -ны № _____ -т

АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА
Н.ЭРДЭНЭ-ОЧИР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус газар нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

07020319

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан


Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	211,572,317.15	204,947,380.85
35	БАРАА МАТЕРИАЛ	210,134,980.15	204,947,380.85
35100	Түүхий эд материал	112,600,950.95	112,462,120.95
35110	Тусгай зориулалттай материал	112,214,420.95	112,092,120.95
35130	Эм боох материал	386,530.00	370,000.00
35400	Хангамжийн материал	96,011,813.20	92,263,043.90
35410	Бичиг хэргийн материал	14,671,558.00	3,459,293.00
35420	Аж ахуйн материал	35,597,343.00	51,512,433.00
35440	Түлш, шатах тослох материал	22,353,724.20	13,902,129.90
35470	Бусад хангамжийн материал	23,389,188.00	23,389,188.00
35600	Мал амьтад	1,522,216.00	222,216.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,984,028,851.79	4,951,462,422.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,984,028,851.79	4,951,462,422.45
39200	Биет хөрөнгө	2,740,413,701.62	4,604,464,272.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,236,155,285.00	4,127,170,148.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-137,568,308.85	-205,393,195.98
39203	Авто-тээврийн хэрэгсэл	356,845,656.57	348,619,835.85
39204	Хуримтлагдсан элэгдэл	-203,937,530.52	-167,673,753.49
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	532,414,188.86	612,760,494.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	-195,413,355.39	-269,046,025.47
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	160,145,693.50	162,945,693.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-59,574,714.15	-90,378,137.08
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	34,721,600.00	34,721,600.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	32,915,839.51	69,843,474.51
39215	Хуримтлагдсан элэгдэл	-16,290,652.91	-19,105,862.00
39300	Биет бус хөрөнгө	243,615,150.17	346,998,150.23
39301	Программ хангамж	2,275,000.00	2,275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,228,249.83	-1,945,249.77
39303	Бусад биет бус хөрөнгө	242,568,400.00	346,668,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,195,601,168.94	5,156,409,803.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	55,584.99
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	55,584.99
41300	Өглөг	0.00	55,584.99
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	55,584.99
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,195,601,168.94	5,156,354,218.31
51	Засгийн газрын хувь оролцоо	3,195,601,168.94	5,156,354,218.31
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,498,240,583.64	1,602,340,583.64
51200	Хуримтлагдсан үр дүн	1,095,813,888.50	2,989,038,133.15
51210	Өмнөх үеийн үр дүн	1,135,364,681.15	1,132,385,083.78
51220	Тайлант үеийн үр дүн	-39,550,792.65	1,856,653,049.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	601,546,696.80	564,975,501.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,195,601,168.94	5,156,409,803.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,541,474,199.64	4,886,497,489.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	203,505,869.64	2,282,927,049.80
120	Нийтлэг татварын бус орлого	195,478,369.64	2,255,679,799.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	68,684,764.00	87,025,153.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	67,457,384.00	67,777,849.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,227,380.00	19,247,304.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	98,885,951.14	2,148,854,807.80
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	27,907,654.50	19,799,839.00
122	Тусламжийн орлого	8,027,500.00	27,247,250.00
122001	Хандив тусламж /дотоод/	0.00	10,000,000.00
122002	Хандив тусламж /гадаад/	8,027,500.00	17,247,250.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,337,968,330.00	2,603,570,440.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,257,182,000.00	2,450,283,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,257,182,000.00	2,450,283,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,786,330.00	153,286,740.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	49,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	80,786,330.00	104,286,740.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,557,895,872.64	2,890,597,909.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,557,895,872.64	2,890,597,909.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,540,989,166.77	2,878,346,155.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,813,927,213.00	1,994,715,770.00
210101	Үндсэн цалин	953,299,791.00	1,026,057,110.00
210102	Нэмэгдэл	827,023,519.00	937,636,165.00
210105	Гэрээт ажлын хөлс	33,603,903.00	31,022,495.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,366,189.13	43,160,911.38
210205	Эрүүл мэндийн даатгал	35,840,204.13	43,160,911.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	165,159,668.00	250,214,862.00
210301	Гэрэл, цахилгаан	32,049,079.00	37,713,465.00
210302	Түлш, халаалт	124,631,001.00	197,529,561.00
210303	Цэвэр, бохир ус	8,479,588.00	14,971,836.00
2104	Хангамж, бараа материалын зардал	129,390,473.80	170,347,998.30
210401	Бичиг хэрэг	18,291,910.00	17,798,900.00
210402	Тээвэр, шатахуун	94,412,366.80	125,649,977.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	11,805,167.00	11,227,001.00

Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	438,030.00	380,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,443,000.00	13,992,120.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	1,300,000.00
2105	Нормативт зардал	35,639,730.00	61,118,991.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	249,000.00	1,434,030.00
210502	Хоол, хүнс	35,045,730.00	58,854,961.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	345,000.00	830,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,424,914.00	79,493,260.00
210604	Урсгал засвар	59,451,724.00	79,493,260.00
2107	Томилолт, зочны зардал	10,850,000.00	13,660,000.00
210702	Дотоод албан томилолт	10,850,000.00	13,660,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,326,840.00	23,826,565.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,049,680.00	6,953,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	25,000.00	2,425,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	450,000.00	450,000.00
210807	Газрын төлбөр	260,000.00	760,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	542,160.00	13,238,565.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	272,904,138.84	241,807,797.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	715,892.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,236,131.20	1,981,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	268,668,007.64	239,110,705.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,906,705.87	12,251,753.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,922,000.00	3,324,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	460,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,422,000.00	2,864,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,984,705.87	8,927,753.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,984,705.87	8,927,753.61
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-16,421,673.00	1,995,899,580.69
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	23,129,119.65	139,246,531.32
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0.00	139,246,531.32
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-39,550,792.65	1,856,653,049.37



2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,412,240,583.64	617,794,485.35	1,119,116,892.60	3,149,151,961.59
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	16,247,788.55	16,247,788.55
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,412,240,583.64	617,794,485.35	1,135,364,681.15	3,165,399,750.14
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-16,247,788.55	0.00	-16,247,788.55
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	86,000,000.00	0.00	0.00	86,000,000.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-39,550,792.65	-39,550,792.65
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,498,240,583.64	601,546,696.80	1,095,813,888.50	3,195,601,168.94
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,498,240,583.64	601,546,696.80	1,095,813,888.50	3,195,601,168.94
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	36,571,195.28	36,571,195.28
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,498,240,583.64	601,546,696.80	1,132,385,083.78	3,232,172,364.22
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-36,571,195.28	0.00	-36,571,195.28
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	104,100,000.00	0.00	0.00	104,100,000.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,856,653,049.37	1,856,653,049.37
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,602,340,583.64	564,975,501.52	2,989,038,133.15	5,156,354,218.31

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,405,425,714.00	2,671,765,626.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	67,457,384.00	68,195,186.00
120	Нийтлэг татварын бус орлого	67,457,384.00	68,195,186.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	67,457,384.00	68,195,186.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	67,457,384.00	68,195,186.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,337,968,330.00	2,603,570,440.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,257,182,000.00	2,450,283,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,257,182,000.00	2,450,283,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,786,330.00	153,286,740.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	49,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	80,786,330.00	104,286,740.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,319,316,064.00	2,616,885,626.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,319,316,064.00	2,616,885,626.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,302,409,358.13	2,604,588,872.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,812,847,565.00	1,995,191,115.39
210101	Үндсэн цалин	985,448,071.00	1,131,390,689.39
210102	Нэмэгдэл	795,139,094.00	830,349,426.00
210105	Гэрээт ажлын хөлс	32,260,400.00	33,451,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,637,464.13	43,345,873.00
210205	Эрүүл мэндийн даатгал	39,637,464.13	43,345,873.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	165,159,668.00	250,214,862.00
210301	Гэрэл, цахилгаан	32,049,079.00	37,713,465.00
210302	Түлш, халаалт	124,631,001.00	197,529,561.00
210303	Цэвэр, бохир ус	8,479,588.00	14,971,836.00
2104	Хангамж, бараа материалын зардал	147,533,457.00	146,853,201.00
210401	Бичиг хэрэг	18,776,510.00	18,681,200.00
210402	Тээвэр, шатахуун	110,689,000.00	108,104,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,590,167.00	12,597,001.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	659,280.00	660,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,698,500.00	6,690,400.00
2105	Нормативт зардал	37,246,260.00	59,484,961.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	272,530.00	1,400,000.00
210502	Хоол, хүнс	36,628,730.00	56,584,961.00

Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	345,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	74,332,264.00	82,598,260.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	718,000.00	1,107,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,990,190.00	1,997,500.00
210604	Урсгал засвар	59,451,724.00	79,493,260.00
2107	Томилолт, зочны зардал	10,850,000.00	13,660,000.00
210702	Дотоод албан томилолт	10,850,000.00	13,660,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,784,680.00	10,568,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,049,680.00	6,933,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	25,000.00	2,425,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	450,000.00	450,000.00
210807	Газрын төлбөр	260,000.00	760,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,018,000.00	2,672,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,018,000.00	2,672,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,906,705.87	12,296,753.61
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,922,000.00	3,369,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,500,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,422,000.00	2,869,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,984,705.87	8,927,753.61
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,984,705.87	8,927,753.61
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	86,109,650.00	54,880,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	86,109,650.00	54,880,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	86,109,650.00	54,880,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	86,109,650.00	54,880,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	86,109,650.00	54,880,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-86,109,650.00	-54,880,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,509,940,200.00	2,509,551,132.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,509,940,200.00	2,509,551,132.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,506,560,200.00	2,506,182,132.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,947,367,600.00	1,947,151,899.39
210101	Үндсэн цалин	1,093,594,000.00	1,093,389,299.39
210102	Нэмэгдэл	820,320,700.00	820,311,600.00
210105	Гэрээт ажлын хөлс	33,452,900.00	33,451,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,386,200.00	42,385,089.00

Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	42,386,200.00	42,385,089.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	244,472,100.00	244,461,422.00
210301	Гэрэл, цахилгаан	33,160,100.00	33,160,025.00
210302	Түлш, халаалт	196,333,800.00	196,329,561.00
210303	Цэвэр, бохир ус	14,978,200.00	14,971,836.00
2104	Хангамж, бараа материалын зардал	131,704,300.00	131,692,401.00
210401	Бичиг хэрэг	18,681,500.00	18,681,200.00
210402	Тээвэр, шатахуун	92,943,800.00	92,943,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,599,000.00	12,597,001.00
210404	Ном, хэвлэл	120,000.00	120,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,000.00	660,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,700,000.00	6,690,400.00
2105	Нормативт зардал	27,975,000.00	27,974,961.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,400,000.00	1,400,000.00
210502	Хоол, хүнс	25,075,000.00	25,074,961.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	86,880,000.00	86,870,760.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,380,000.00	5,380,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,000,000.00	1,997,500.00
210604	Урсгал засвар	79,500,000.00	79,493,260.00
2107	Томилолт, зочны зардал	12,640,000.00	12,580,000.00
210702	Дотоод албан томилолт	12,640,000.00	12,580,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,635,000.00	10,568,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,000,000.00	6,933,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,425,000.00	2,425,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	450,000.00	450,000.00
210807	Газрын төлбөр	760,000.00	760,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	2,497,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,500,000.00	2,497,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,380,000.00	3,369,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,380,000.00	3,369,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,880,000.00	2,869,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,509,940,200.00	2,509,551,132.39
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,450,283,700.00	2,441,355,946.39
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,450,283,700.00	2,441,355,946.39
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	59,656,500.00	68,195,186.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,656,500.00	68,195,186.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	153,286,740.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	153,286,740.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	153,286,740.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,039,216.00
210101	Үндсэн цалин	38,001,390.00
210102	Нэмэгдэл	10,037,826.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	960,784.00
210205	Эрүүл мэндийн даатгал	960,784.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,753,440.00
210301	Гэрэл, цахилгаан	4,553,440.00
210302	Түлш, халаалт	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,160,800.00
210402	Тээвэр, шатахуун	15,160,800.00
2105	Нормативт зардал	31,510,000.00
210502	Хоол, хүнс	31,510,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,607,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,607,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,080,000.00
210702	Дотоод албан томилолт	1,080,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	175,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	175,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	153,286,740.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	153,286,740.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	153,286,740.00



3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэнханд гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 31-01/401 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хууль зүйн дотоод хэргийн яамны харьяа төрийн тусгай албаны нийтийн хэв журам сахиулах босоо тогтолцоотой байгууллага бөгөөд “Удирдах ажилтны манлайлал алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах” зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль эрх зүйд өөрчлөлт ороогүй.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 2,581.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 51.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 41.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд 2021 оны нийт зардал 2,890.6 сая төгрөгөөс 2 хувиар тооцоход 57.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 46.2 сая төгрөгөөр тооцсон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говь-Алтай аймгийн Цагдаагийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38 хувиар буюу 1,960.8 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 204.9 сая төгрөг болж 5.1 сая төгрөгөөр буурсан нь бараа материалын зарцуулалт нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 243.9 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр НҮБ-ийн хүүхдийн сангаас 5.3 сая төгрөгийн, ЦЕГ-аас 17.4 сая төгрөгийн шатахуун, аж ахуйн материал, 5.6 сая төгрөгийн шатахууны талоны урамшуулал, үнэ төлбөргүй ирсэн хонь 5 буюу 1.25 сая төгрөгийн нийт 397.9 сая төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагаандаа 276.2 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,598.0 сая төгрөг болж 2,106.9 сая төгрөгөөр өссөн нь шинээр ашиглалтад орсон барилга байгууламж, газрыг нэмж бүртгэсэнтэй холбоотой. Мөн ЦЕГ, НҮБ-ийн хүүхдийн сан, бусад эх үүсвэрээс 148.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,156.3 сая төгрөг болж 1,960.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 38 хувиар буюу 49.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн дүнгээс шалтгаалсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 2,989.0 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,259.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 749.2 сая төгрөгөөр бууруулж, 2,509.9 сая төгрөгөөр баталжээ.



3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 4 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 2,450.2 сая төгрөгийн, өөрийн орлогоос 59.6 сая төгрөгийн нийт 2,509.9 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,518.5 сая төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоос 68.1 сая төгрөг орж, урсгал үйл ажиллагаанд 2,509.1 сая төгрөгийг зарцуулж 8.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,509.9 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн засаг даргын нөөц хөрөнгөнөөс 49.0 сая төгрөг, цар тахалтай холбоотойгоор бусад эх үүсвэрээс 104.3 сая төгрөг нийт 153.3 сая төгрөгийн орлого орсноос дотоодын цэргийн цалинд 49.0 сая төгрөгийг, байр ашиглалттай холбоотой зардалд 5.7 сая төгрөгийг, багаж техник хэрэгсэл худалдан авахад 50.6 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 15.6 сая төгрөгийг, хоол хүнсэнд 31.5 сая төгрөгийг, албан томилолтын зардалд 1.0 сая төгрөгийг зарцуулжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.


3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, НӨАТ-ийн тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 2021 оны 908.2 сая төгрөгийн 32 мэдээллийг ил тод байршуулахаас 908.2 сая төгрөгийн 32 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.



3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд 24.6 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлснийг аудитын явцад залруулсан

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Татварын ерөнхий хуулийн 28., 2-т " Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3 дахь заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 4.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 3.7 сая төгрөгийн албан шаардлага, 25.0 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар шатахуун, бараа материалын тайлангийн тулгалт, авлагын барагдуулалтыг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 33.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 31.1 сая төгрөгийн алдааг залруулан, 1.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 0.24 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Аймгийн Эрүүл мэндийн газраас цар тахалтай холбоотой өгсөн 5 хонийг НББ-д тусгаагүй байна.

Тайлант онд 24.6 сая төгрөгийн худалдан авалтын и баримтыг дутуу шивүүлснийг аудитын явцад залруулсан

Санхүүгийн тайлангийн өглөг, авлага, татварын хэлтсийн тайлангаас 5.2 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг тооцоо нийлж залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Шатахуунаас 1.7 сая төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй тул төлбөрийн акт тогтоолоо.


4.3 Албан шаардлага

Эдийн засгийн ангилал зөрчин 0.24 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" "Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаал, 2021 оны 190 дүгээр тушаал" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цагдаагийн газар	5	33.0	3	31.1	1	1.7	1	0.24		
	Дүн	5	33.0	3	31.1	1	1.7	1	0.24		



ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ХУУДАС

1. Ерөнхий мэдээлэл

Код:	
Баримт бичгийн төрөл	Санхүүгийн тайлангийн аудит
Аудитын нэр	Цагдаагийн газар
Хугацаа заасан эсэх	Тийм <input type="checkbox"/> Үгүй
Ажил гүйцэтгэсэн:	Ахлах аудитор Аудитын менежер

Handwritten signature

Д.Цэрэнханд

Д.Эрдэнэчимэг

2. Гүйцэтгэсэн ажлын чанарын хяналтын эргэцийн хүснэгт

Огноо		Чанарын хяналт хийсэн хүний шийдвэр, үнэлгээ			Чанарын хяналт хийсэн хүний санал, зөвлөмжийн товч утга	Гарын үсэг	Санал зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн хяналт	Тайлбар
Хүлээн авсан	Буцааж өгсөн	Хангалттай	Засвар, зөвлөмжийг оруулж дараагийн шатанд шилжүүлэх	Засвар хийгээд дахин үзүүлэх				
2022.02.22	2022.02.22	+			Дараагийн шатанд хянуулах	Ж.Бүжинханд	Хянуулахаар өглөө	
2022.02.22	2022.02.22	+			Засгийн газрын 43 дугаар тогтоол хамаарах билүү, Аудитын тайланд эрхэм зорилго бус зорилт, зорилго бичигдэнэ. Аудитын гэрчилгээнд өөр байгнууллагын нэр байна. Аудитын тайланд шараар будсан хэсгийг засах	Д.Эрдэнэчимэг	Тайлангаас 43-ийг хаслаа	
2022.02.22	2022.02.22	+			Аудитын тайланд товчилсон үгээ товчилсон үгийн жагсаалтад оруулахАкт дээр шарлуусан хэсгийг засаарай	Д.Эрдэнэчимэг	Товчилсон үгийг нэмж орууллаа.	
2022.02.24	2022.02.24	+			Тайланд үг үсгийн болон тоон задаргаа алдаатайг шараар будлаа засах	Х.Түвшинбаяр	Тайланд заслаа	
2022.02.24	2022.02.24	+			Шийдвэрийг Сайханжаргалаар хянуулаад хэвлэх	Х.Түвшинбаяр	хянуулахаар 2022.02.24-нд өглөө	

Аудитын тайланг баталгаажуулахыг зөвшөөрсөн

Дарга, Тэргүүлэх аудитор

/ Х.Түвшинбаяр/

... оны ... сарын ...



8217144139

ДНСА00000018301